

Дэлхийн том хичээл – Тогтвортой хөгжлийн боловсрол

Хөвсгөл аймаг Мөрөн сумын Танилхан IX цэцэрлэг



Нас: 4

Хугацаа : 20-25 минут

СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ

Сэдэв: “Нэг дэлхий - Нэг гэр бүл” сургамжит өгүүллэг

Дэлхийн бүх хүүхдүүд ёс заншил, арьс өнгө өөр өөр ч хэрэглээ, хэрэгцээ ижил гэдгийг ойлгож үл ялгаварлан, хуваалцах, хамтран оршино.

Сургалтын хэлбэр: Танин мэдэхүйн үйл ажиллагаанд суурилсан.

Зорилго: Өөрт байгаа зүйлээ бусадтай хуваалцах хандлагад суралцана.

Зорилт:

- Дэлхийн хүмүүс өөр өөр ч хоол тэжээлийн хэрэгцээ ижил гэдгийг мэдэх.
- Өөрт байгаа зүйлсээ бусадтай хуваалцах хандлагыг дэмжих.
- Дасгал даалгавар гүйцэтгэж, өөрийн санаа бодлоо илэрхийлэх.
- Хамтран ярилцаж, тоглож, дуулж, сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэх.

Агуулга : “Хэн ч хэрэглэж болно” гэсэн эелдэг үгийг ойлгон өөрт байгаа зүйлсээ бусадтай хуваалцсанаар дэлхий нийтээр хамтдаа өлсгөлөнгүй, ядууралгүй, энх тайвнаар эрх тэгш оршин тогтнож болох тухай.

Хэрэглэгдэхүүн:

Дэлгэц, дүрс бичлэг, өгүүллэг, ажлын даалгавар 1,2, монгол, орос, япон, америк, африк хүүхдүүдийн зурган карт хүүхдийн тоогоор.

Цахим холбоос : <https://www.youtube.com/watch?v=1EzMOKC9vP8>

<https://www.youtube.com/watch?v=2V996CT-JHo>

<https://online.fliphtml5.com/heoqa/jpxu/>

Арга зүй :

- Дэлгэцээр үзүүлэх арга
- Ажиглах арга
- Уран зохиолтой танилцуулах арга
- Харилцан ярилцах арга
- Тестийн арга
- Тоглоомын арга

Алхам 1 /7 минут/

“Нэг дэлхий – Нэг гэр бүл” сургамжит өгүүллэгийн дүрс бичлэгийг дэлгэцээр үзүүлэх.

Хавсралт – 1 / CD, эх бичвэр /

- Энэ өгүүллэгийн үйл явдал та нарт таалагдсан уу? Яагаад?

Алхам 2. /5 минут/


Асуулт, ярилцлага

- Өгүүллэгт ямар үйл явдалын тухай гарсан бэ?
- Хүүхдүүд өөрийнхөө авчирсан зүйлсээ яагаад үлдээсэн бэ?
- Чи эдгээр хүүхдүүд шиг бусадтай өөрт байгаа зүйлсээ хуваалцдаг уу?
- Чи энд байсан бол энэ хүүхдүүдтэй юугаа хуваалцах байсан бэ? Бодоод хариулаарай. Багш дээрх асуултуудын хариултыг сонсож, харилцан ярилцана.

Алхам 3. /7 минут/

Дасгал даалгавар

Даалгавар 1: Хэн ямар хүнс авч ирснийг тохируулан холбоорой. /Хавсралт 2/



Даалгавар 2: Даалгаварын зүүн талд байгаа хоёр хүүхдийг ажиглаарай. Хэрвээ чи эмэгтэй бол эмэгтэй хүүхдийг, эрэгтэй бол эрэгтэй хүүхдийн зургыг дугуйлаарай. Дугуйлсан хүүхдийг өөрийгөө гэж төсөөлөөрэй. Тойрсон зургуудийг нэрлээрэй. Эдгээр зүйлсээс алийг нь хэнтэй хуваалцмаар байна вэ? холбож зураарай. /Хавсралт 2/



Дасгал гүйцэтгэсний дараа доорх асуултыг тавьж ярилцана.

- Яагаад эдгээр хүүхдүүдтэй үүнийг хуваалцах болсон бэ?
- Өөрт байгаа зүйлээ бусадтай хуваалцахад чамд ямар сэтгэгдэл төрсөн бэ?

Алхам 4. /5 минут/

Тоглоом

“Дэлхий инээж байна” тоглоомыг дүрмийн дагуу тоглоно. /Хавсралт 3/

Тоглоомын явцад багш анхааралтай, идэвхтэй, баяр баясгалантай оролцоог дэмжиж идэвхжүүлнэ.



Тоглож дууссаны дараа багш:

- Бид ямар нэртэй тоглоом тоглосон бэ?
- “Дэлхий инээж байна” тоглоом хөгжилтэй байсан уу?

Баяр баясгалантай, идэвхтэй оролцсон хүүхдүүддээ баярлалаа.

Боловсруулсан багш: П.Алтанцэцэг

Хавсралт 1

Нэг дэлхий - Нэг гэр бүл

(Сургамжит өгүүллэг)

Орон орны хүүхдүүд айлчилсан ойн цоорхойд Монгол хүү иржээ. Явж явж амрахаар суухдаа ээжийнхээ бэлтгэн өгсөн ааруулыг амтархан идлээ. Ааруул нь их сайхан амттай байсан учир хэн нэгэнтэй хувааж идмээр санагджээ. Ингээд модны сүүдэрт амрахдаа “Хэн ч хэрэглэж болно” гэж бичээд ааруулаа тавганд хийж тавиад унтжээ. Монголчууд ааруулыг байгалийн ургамлаар хооллосон, малын сүүг хөөрүүлэн, тараг бүрж, таргаа буцалган аарц болгоод аарцаа уутанд хийн шүүж, төрөл бүрийн хэв, хэлбэрт оруулан зүсч, хатаан хийдэг, амин дэмээр баялаг цагаан идээний нэг төрөл юм.

Энэ үед орос охин ирлээ. “Хэн ч хэрэглэж болно” гэнээ. Ямар сайхан сэтгэлтэй юм бэ? Би аарууланд маш их дуртай шүү дээ гээд тавагтай ааруулыг амтархан идлээ. “Хоосон таваг орхивол Монгол найз минь гомдоно байх даа” гээд тавганд нь өөрийн авч явсан талхаа үлдээгээд явлаа. Талхыг гурил, давс, усаар зуурч исгэж, жигнэж хийнэ. Талх нь ислэг ихтэй бүтээгдэхүүн бөгөөд биеийн хорыг гадагшлуулж, илүүдэл жингээс сэргийлнэ.

Удалгүй Япон хүү ирэн “Хэн ч хэрэглэж болно” гэсэн бичгийг уншаад тавагтай талхнаас амтархан идээд өөрт байсан будаагаа үлдээгээд явлаа. Монгол хүү унтсаар л байлаа. Цагаан будааг чийглэг хөрсөнд тарьж ургуулдаг. Цагаан будаанд олон төрлийн амин хүчлүүд байдаг тул ходоод гэдэсний хямрал болон эмчилгээ сувилгаанд ашиглах зэрэг олон ач тустай.

Дараа нь Африк хүүхэд хураасан жимсээ барьсаар ирлээ. “Хэн ч хэрэглэж болно” гэсэн бичгийг хараад баярлан, будааг амтархан идээд талархлаа илэрхийлж, өөрийн авч явсан олон төрлийн жимснээсээ тавганд үлдээгээд явлаа. Жимс нь мод, бут гэх мэт ургамлын шүүслэг үр бөгөөд хүний биед амархан шингэдэг, амин дэмээр баялаг шим тэжээлт хүнсний бүтээгдэхүүн юм.

Энэ үед Америк хүү гартаа бургер барьсаар ойн цоорхойд ирлээ. “Хэн ч хэрэглэж болно” гэсэн болохоор тавагтай жимснээс амтархан идээд тавганд нь бургерээ хийж орхиод явлаа. Бургер нь шим тэжээл сайтай шинэ ногоо махаар хийдэг, бэлтгэхэд амархан авч явахад хялбар бүтээгдэхүүн юм.

Монгол хүү нойрноосоо сэрээд гайхан дуу алдлаа. “Яасан сонин юм бэ? Би зөвхөн ааруул хийж тавьсан даа. Амтат бургер болчихсон байх юм ямар гоё юм бэ гэж баярлав. Ингээд тавагтай бургерээ авч явах гэснээ сайхан сэтгэл гаргасан хүн бүхэнтэй хуваалцахаар шийдээд үлдээгээд явлаа.

Энэ цагаас хойш ойн цоорхойд аялж ирсэн хүүхдүүд өөрт байгаа бүхнээ “Хэн ч хэрэглэж болно” гэсэн бичгийн доор үлдээгээд бусадтай хуваалцдаг болжээ.

Таван тивийн хүүхдүүд

Тайван амгалан аялж байна.

Оршин амьдрах тив нь өөр ч

Орчлонд бид нэг дэлхийтэй.

Хэн ч хэрэглэж болно гээд

Хүүхэд бүрийг дайлж байна

Хүссэн бүхэн нь биелж

Хүж дэлхий жаргалтай байна.

Хавсралт-2

Даалгавар 1 :



Даалгавар 2 :



Хавсралт 3

“ Дэлхий инээж байна ” (Хөдөлгөөнт тоглоом)

Зорилго: Сонсох, ажиглах, хамтран гүйцэтгэх, баяр баясгалантай байдлыг дэмжинэ.

Хэрэглэгдэхүүн: Монгол, орос, япон, америк, африк хүүхдийн зургийг тус бүр бш, бэлтгэнэ.

Зохион байгуулалт: Хүүхдүүд өөрийн сонгосон хүүхдийн зургийг урдаа барьж тойрог болон зогсоно. Удирдагч тойргийн голд зогсоно.

Дүрэм: Өөрийн дуртай орны хүүхдийн зургийг сонгоно. Багшийн яриаг анхааралтай сонсож, үг хөдөлгөөнөөр гүйцэтгэнэ.

Удирдагч: Ааруул авчирч хуваалцсан хүүхэд ямар орны хүүхэд вэ? гэж асууна. Хүүхдүүд тааж хэлээд зургийг барьсан хүүхдүүд хэлээд урагшаа 1 алхан “Дэлхий инээж байна” гэж хэлээд, 2 гараараа толгойн орой дээр зүрх дүрслэн мэхийн ёслоно.

Удирдагч: Улаан даашинзтай, цагаан цамцтай сагстай талх хуваалцсан охин ямар орны хүүхэд вэ? гэж асууна. Хүүхдүүд тааж хэлээд зургийг барьсан хүүхдүүд урагшаа 1 алхан “Дэлхий инээж байна” гэж хэлээд 2 гараараа толгойн орой дээр зүрх дүрслэн мэхийн ёслон байраа эзлэн зогсоно.

Удирдагч: хар хувцастай, будаагаа хуваалцсан хүү ямар орны хүүхэд вэ? гэж асууна. Хүүхдүүд тааж хэлээд, зургийг барьсан хүүхдүүд урагшаа 1 алхан “Дэлхий инээж байна” гэж хэлээд 2 гараараа толгойн орой дээр зүрх дүрслэн мэхийн ёслон байраа эзлэн зогсоно.

Удирдагч: Буржгар үстэй жимсээ хуваалцсан хүү ямар орны хүүхэд вэ? гэж асууна. Хүүхдүүд тааж хэлээд, зургийг барьсан хүүхдүүд урагшаа 1 алхан “Дэлхий инээж байна” гэж хэлээд 2 гараараа толгойн орой дээр зүрх дүрслэн мэхийн ёслон байраа эзлэн зогсоно.

Удирдагч: Шар малгайтай, цагаан цамцтай бургер хуваалцсан хүү ямар орны хүүхэд вэ? гэж асууна. Хүүхдүүд тааж хэлээд, зургийг авсан хүүхдүүд урагшаа 1 алхан “Дэлхий инээж байна” гэж хэлээд 2 гараараа толгойн орой дээр зүрх дүрслэн мэхийн ёслоно. Байраа эзлэн зогсоно.

Төгсгөл: Үг: Ж.Дашдондог Ая :Т.Чимэддорж “Сайн байна уу?” дууны аянд 2,2-оороо зөрж, тохойгоо зөрүүлэн барьж эргэлдэн бүжиглэнэ. Мэхийн талархаад тоглоомоо дуусгана. .

Хавсралт 4

Эцэг эхэд өгөх зөвлөмж

- Өөрт байгаа зүйлээ бусадтай харамгүй хуваалах хандлагад суралцуулаарай.
- Өөрөөсөө түрүүнд бусдыг хүндлэх эрхэм гэдгийг үлгэрлээрэй.
- Талархалын үгийг хэрэглэж хэвшүүлээрэй.
- Өөрийнхөө эрхэмлэдэг сайхан зүйлсээ бусадтай хуваалцахдаа сэтгэл хангалуун, баяр баясалтай байх хэрэгтэй гэдгийг төлөвшүүлээрэй.

Багшид өгөх зөвлөмж

- Энэхүү өгүүллэгийг хувилбартайгаар зохиомжлон үйл ажиллагаандаа хэрэгжүүлж болно./өөрийн бүлгийн насны онцлогт тохируулан хувцас, хоол, хөдөлмөр, бэлэг, мэндчилгээ, мод, цэцэг тарих гэх мэт/
- Ширээны театр, хормогчин театр, хуруу хүүхэлдэй, комик, анимешн хэлбэрээр танхимын болон цахим сургалтыг зохион байгуулж болно.
- Хүүхдүүдээр жүжигчилсэн тоглолт хийлгэх.
- Сургалтын чиглэлүүдтэй холбон хэрэгжүүлж болно.